

БАТЛАВ.
УРАЛДААН ТЭМЦЭЭНИЙГ ЗОХИОН
БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН АХЛАГЧ,
АНУ ДАХЬ МОНГОЛ СУРГУУЛИУДЫН
НЭГДСЭН ЗӨВЛӨЛИЙН ТЭРГҮҮН:
.....ДҮҮРЭН ВУОЛТЭРС

МОНГОЛ БАХАРХАЛЫН ӨДРИЙГ ТОХИОЛДУУЛАН ЗОХИОН БАЙГУУЛАГДАХ
“БИ МОНГОЛ ХҮН” ТАНИН МЭДЭХҮЙН УРАЛДААНТ ТЭМЦЭЭНИЙ
УДИРДАМЖ

2025 оны 09 дүгээр
сарын 10 - ны өдөр

Вашингтон ДиСи хот

АНУ-д өсөж төрнөж буй өсвөр насны хүүхдүүдийн дунд зохион байгуулагддаг
“БИ МОНГОЛ ХҮН” танин мэдэхүйн IV тэмцээн энэ жилээс МОНГОЛ БАХАРХАЛЫН
ӨДӨР”-ийг тохиолдуулан зохион байгуулагдахаар боллоо.

Зорилго: АНУ-д амьдарч буй өсвөр насны Монгол хүүхдүүдийн эх хэлээ сурч
мэдэх гэсэн хүсэл эрмэлзлэлийг нь дэмжин хөгжүүлж, Монгол хэлийг үр дүнтэйгээр
ашиглах, эх хэлээрээ ярьж, харилцан бие биенээсээ суралцах таатай орчинг
бүрдүүлэн, тэдэнд Монголын нууц товчоо, нүүдэлчин ахуй, соёл, ёс заншлын
талаар зохих мэдлэгийг олгоход оршино.

Санаачлагч: “We Together” Хүүхэд, Гэр Бүлийн Хөгжлийг Дэмжих Төв

Хамтран зохион байгуулагчид:

1. Монгол Улсаас АНУ-д суугаа Элчин сайдын яам
2. АНУ дахь Монгол сургуулиудын зөвлөл
3. Вашингтон ДиСи орчмын Монголчуудын Холбоо
4. АНУ-ын нийслэл дэх Монгол сургууль
5. “Монгол Эрдэм” сургууль
6. Mongol Archery Group
7. ДиСи Шагайн Клуб
8. “Андгай” Боловсрол, соёлын клуб
9. Nomads Hustle

10. We Mongolians in the USA
11. Society of Mongolian Researchers in the USA
12. “WE TOGETHER” Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн төв

Нэг. Хамрах хүрээ: АНУ-д амьдардаг дунд болон ахлах сургуулийн сурагчид

Хоёр. Хугацаа:

Тэмцээн 2025 оны 11-р сарын 23-ны өдрийн 10:00-17:00 цагт “K-Community Center”-т зохион байгуулагдана.

Бүртгэл 2024.11.20-ныг дуустал явагдана. Бүртгэл дууссаны дараа зохион байгуулагчдын зүгээс оролцогч мужуудын багш, эцэг эхчүүдийн төлөөллийг оролцуулсан тусгай баг томилон, нийт бүртгүүлсэн хүүхдүүдийн анги, нас, Монгол хэлний түвшин зэргийг харгалзан үзсэний үндсэн дээр хүч тэнцвэртэй байлгахад анхаарч багийн хуваарилалтыг хийнэ. Нэг баг 5 хүүхэдтэй байна.

Тэмцээнд оролцох хүүхдүүд 2025/09/22-2025/11/22-ны өдрийг хүртэл 2 сарын хугацаанд “Миний эх нутаг - Монголын сайхан орон” сэдэвт 8 удаагийн цахим хичээлийг бие даан судалсан байх шаардлагатай.

Гурав. Зохион байгуулалт

1. Тэмцээнд оролцох хүсэлтэй дунд болон ахлах сургуулийн хүүхдүүдийг бүртгэх удирдамжид заасан хугацаанд бүртгэж, холбогдох мэдээллээр хангана.
2. Тэмцээн ганцаарчилсан болон багийн гэсэн 2 төрлөөр зохион байгуулагдана.
3. Ганцаарчилсан ангилалд оролцогчид дараах төрлүүдээс сонгон бүртгүүлэх ба сэдвийг шалгаруулалтын өдөр оролцогчдод танилцуулна.
 - Зохион бичлэг (1000 үгэнд багтаан бичих)
 - Уран зураг (Ватм цаасан дээр зурах)
 - Уран уншлага (Видео бичлэг хийж илгээх)
4. Энэ ангилалд оролцогчдын шалгаруулалтыг тухайн мужид үйл ажиллагаа явуулдаг Монгол сургуулиудтай хамтран 2025 оны 11-р сарын 13-ны өдөр тус тус зохион байгуулж явуулна.

5. Багийн ангилалд оролцогчдын тэмцээн нийт 4-н үе шаттайгаар зохион байгуулагдана.

Нэгдүгээр үе шат: 5 оноо

- Багийн гишүүд хамтдаа ханын сонин хийнэ. (Ханын сонингийн сэдэв сугалуулах ба багууд 15 мин бэлдэж, 2 минутанд тайлбарлан ярина.)

Хоёрдугаар үе шат: 5 оноо

- Багуудын дундах асуулт хариултын тэмцээн - **5 оноо** (Багийн бүх гишүүд оролцож 5 асуултанд хариулна. 1 асуулт 1 оноо байна.)

Гуравдугаар үе шат: 5 оноо

- Багийн мэндчилгээ (5 min)
(Багууд мэндчилгээндээ дуу, шүлэг, бүжиг, жүжигчилсэн тоглолт, хөгжим тоглох гэх мэт багууд хүссэн зүйлээ үзүүлэх боломжтой боловч багийн гишүүдийн жигд оролцоо, хувцаслалт, ур чадварт тулгуурлан шүүгчид оноо өгнө гэдгийг анхаарна уу.)

Дөрөвдүгээр үе шат: 5 оноо

- Багийн ахлагч нарын тэмцээн - 3 мин
(Багийн ахлагчидаар сугалаа сугалууна. Сугалаанд 1 түргэн хэллэг, 1 ёгт үлгэр байх бөгөөд багийн ахлагч нар түргэн хэллэгийг хэлж, ёгт үлгэрийг уншин юун талаар өгүүлснийг тайлбарлана.)

Дөрөв. Шагналын сан:

Багийн ангилал:

- 1-р байр ӨРГӨМЖЛӨЛ + МӨНГӨН ШАГНАЛ (\$1000)
- 2-р байр ӨРГӨМЖЛӨЛ + МӨНГӨН ШАГНАЛ (\$700)
- 3-р байр ӨРГӨМЖЛӨЛ + МӨНГӨН ШАГНАЛ (\$500)

Ганчаарчилсан ангилал:

- 1-р байр ӨРГӨМЖЛӨЛ + МӨНГӨН ШАГНАЛ (\$200)
- 2-р байр ӨРГӨМЖЛӨЛ + МӨНГӨН ШАГНАЛ (\$100)
- 3-р байр ӨРГӨМЖЛӨЛ + МӨНГӨН ШАГНАЛ (\$50)